



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 0/68

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын 30 дугаар сургуулийн эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2023 оны А/15 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 17,864,598.98 (арван долоон сая найман зуун жаран дөрвөн мянга таван зуун ерэн найман төгрөг ерэн найман мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан ном, сурах бичгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 30 дугаар сургууль (П.Өлзийтөгс)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 7435 ширхэг нийт 17,864,598.98 (арван долоон сая найман зуун жаран дөрвөн мянга таван зуун ерэн найман төгрөг ерэн найман мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий ном, сурах бичгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохих журмын дагуу устгалын акт үйлдэн устгахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 30 дугаар сургууль (П.Өлзийтөгс)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150500274

